

МОНГОЛЧУУДЫН ЭРТНИЙ ТҮҮХ БИЧЛЭГИЙН ЗАРИМ ОНЦЛОГООС

(Археологийн судалгаан дээр)

С.Өлзийбаяр

Шинжлэх Ухаан Академийн Түүхийн хүрээлэн, sulzii70@yahoo.com

Өгүүллийн товч утга: Судар бичгийн хүрээлэнгээс түүх соёлын дурсгалыг олж илрүүлэх, бүртгэн тэмдэглэхээс эхэлсэн монголчуудын хийж ирсэн археологийн судалгаа нь өнөө үеийг хүрэхдээ хөгжлийн тодорхой үеүүдийг туулсаар иржээ.

Түлхүүр үг: Тахилтын хотгор, Тамирын Улаан хошуу, Гол мод, Гол мод II, Ноён уул, Дуурилаг нарс, Өгөөмөр уул

Монголчууд XIII зуунаас өмнөх эх түүхээ дагнан судлах болсноос өнөө үеийг хүртэл олон арваныг үдэхдээ онол-арга зүйн харилцан өөр баримтлал бүхий түүх бичлэгийн тодорхой үеүүдийг туулж өнгөрүүлсэн ч монголын эртний түүхийн баялаг хэрэглэгдэхүүнд тулгуурлан өвөг дээдсийнхээ бүс нутгийн болон дэлхийн түүхэнд гүйцэтгэсээр ирсэн үүргийг үнэн зөвөөр гаргаж тавих голч шугамаас гажаагүй юм. XX зууны Монголын нийгмийн амьдралд марксист-ленинист үзэл суртал гүнзгийрэхийн хирээр эх түүхээ судлах онол-арга зүйн чиг хандлага ихээхэн өөрчлөгдөн хувьсаж, бүх үеийн түүхийг ангич байр сууринаас харах болсон байна. Монголын түүх бичлэгт марксист-ленинист үзэл суртал нэвтэрсэн өнгө төрх, аясаар нь ерөнхийд нь:

- 1921-1940 -өөд оны сүүлч хүртэл марксист-ленинист үзэл санаанд алхам, алхамаар автсан үе

- 1949-1960-аад оны эхэн үед марксист түүх бичлэг эргэлтгүй ноёрхох болж, монголын түүхийн шинжлэх ухаанд марксист-ленинист онол арга зүй үндсэндээ төлөвшин тогтсон үе

- 1960-аад оноос 1980-аад оны эцэс хүртэл БНМАУ-д марксист-ленинист онол арга зүйд тулгуурласан түүхийн шинжлэх ухааны хөгжил эрс эрчимжсэн үе хэмээн зааглагдаж болох¹ тухай судлаачдын дэвшүүлсэн үзэл баримтлал шинэ үеийн монголын түүх бичлэгийн онол-арга зүйн гол хандлага болон төлөвшиж байна. Бид энэхүү онолын үзэл баримтлалын хүрээнд манай шинэ үеийн судлаач, эрдэмтдийн Их Монгол улсаас өмнөх үеийн түүх бичлэгийг арга зүйн ерөнхий хандлагаар нь хөгжлийн дараах дөрвөн үе шатыг дамжин ирсэн гэж үзэж болохоор байна.

- Буддын шашны онол арга зүйг халж, шинэ боловсрол, шинжлэх ухаанч арга зүйг нэвтрүүлэх, марксист түүх бичлэгийн нөлөөн дор аажим орж эхэлсэн үе буюу 1921-1940-өөд оны төгсгөл үеийнхний эртний түүх бичлэг. Өгүүлэн буй үеийн эртний түүхийн судалгаа нь уламжлалт түүх бичлэгээс тэс өөрөөр, шинжлэх ухааны онол-арга зүйг удирдлага болгосон бичлэгийн хэв маяг нэвтэрсний зэрэгцээ археологийн мэдээ сэлт цуглуулах түүнд дүн шинжилгээ хийх гэсэн цоо шинэ үзэгдэл гарч эхэлсэн гол онцлогтой юм. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын дараа Судар бичгийн хүрээлэн, Үндэсний музей зэрэг байгууллагууд бий болсон нь монголчуудын өвөг дээдсээсээ өвлөн ирсэн түүх, соёлын баялаг их өвийг судлах өргөн их боломжийг бүрдүүлжээ.

Мөн үеийн археологийн судалгаа нь Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд 1924 онд байгуулагдсан Түүхийн кабинетаас монгол орны эрт үеийн түүхийн

¹ Ж.Болдбаатар, Д.Батбаяр. Монголын түүх бичлэгийн тулгамдсан асуудлууд // XX зууны Монголын түүхийн судалгаа, түүх бичлэгийн зарим асуудал УБ., 2005

дурсгалыг олж сурвалжлах, бүртгэх ажлыг эхлүүлснээр сууриа тавьжээ. Энэхүү судалгаа нь 1922 оноос Монгол Ард Улсын Судар бичгийн хүрээлэн, СССР-ийн ШУА хоёрын хамтын хүчин чармайлтын үрээр манай орны энд тэнд орших соёл-түүхийн дурсгал: хөшөө, булш, хуучин хот, хэрмийг шинээр нээн олж, хөндөн малтах² ажлаас эхэлсэн нь анхнаасаа шинжлэх ухаанч мөн чанартай байжээ. Монгол нь дэлхийд хосгүй дурсгалыг хадгалсан орон болох нь XIX зууны сүүлээс Монгол нутгийг зорьсон Оросын болон гадаадын шинжилгээний ангийн тайлан мэдээ, Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн XX зууны 20-30-аад онд хийсэн судалгаа, ялангуяа 1924-1925 онд Зөвлөлтийн эрдэмтэн П.К.Козлов Ноён уулаас Хүннүгийн дэлхийд алдаршсан зартай нээлтээр улам тодорхой болсон билээ. Эдгээр нь дэлхий дахинаа монгол орныг бас нэгэн үзүүлэлтээр таниулсан чухал үйл явдал болж байгаа нь манай үндэсний сэхээтнүүдийн судалгааных нь урам зоригийг хөгжөөсөн шууд нөлөөлөл болсон нь дамжиггүй юм. Тухайлбал, ...Ж.Цэвээн 1922 оноос Монгол Ард Улсын олон газар нутгийн сэхээтэн, идэвхтэн нартай биечлэн уулзаж, бичиглэн харилцаж, өргөн холбоо байгуулж, ховор нандин соёл-түүхийн дурсгалуудыг олж мэдэх үлэмж их ажлыг хийсэн, О.Жамъян Монголын археологийн дурсгалуудыг биечлэн сурвалжилж, хөдөө нутагт явдаг... Н.Дэндэв, орос эрдэмтэн нарыг дагалдан ажиллаж байсан³ нь үүний тодорхой гэрч болох юм. 1924 онд Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор Судар бичгийн хүрээлэнгээс "Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм", "Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо" зэрэг эрх зүйн баримтуудыг мөрдүүлэхээр гаргасан нь эртний эд зүйлсийг шинжлэх ухаанч зарчмаар судлах үйл ажиллагааны үндсэн чиглэл байсан юм. 1930-аад оны Монголын нийгмийг хамарсан их хэлмэгдүүлэлтээр үндэсний олон арван сэхээтнүүдийг хилсдүүлэн, хуучны дурсгалуудыг эвдэн устгасан нь үр хөврөл нь тавигдах төдий байсан шинжлэх ухаанч эртний судлалын цаашдын хөгжлийг боогдуулсан билээ. Энэ зохисгүй үзэгдлийг ангич байр сууринаас хандан шинжлэх ухааны хүрээлэн өөрийн үйл ажиллагааныхаа замналд зөвхөн материаллаг бааз, боловсролтой ажилтнаар дутагдаад зогсоогүй, бас үзэл суртлын хувьд ч доголдох бэрхшээлтэй тулгарсан гээд ... феодалын өнгөрсөн үе ба тэр үед шинээр төрж эхэлж байсан хөрөнгөтөн этгээдүүдийн үзэл суртлыг илэрхийлсэн баруунтнаас намын эсрэг хийж байсан явуулга нь хувьсгалт соёл хөгжиж, хөдөлмөрчдийн ертөнцийг үзэх марксист-ленинист үзэл төлөвшин тогтоход саад тотгор учруулж байсан⁴ гэж үзэл сурталчлуулан ойлгосоор иржээ. Гэвч энэ үед Монголын засаг төрөөс өөрийн нутаг дээрх түүх-соёлын дурсгалыг шинээр олж илрүүлэх, авран хамгаалахад чиг үүргээсээ ухраагүй юм. Үүний тод илрэл нь 1935 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүрэлдэхүүнд Түүхийн тасгийг байгуулан "...Монгол газар бүхий дурсгалт хөшөө балгас зэргийг бүртгэн тэмдэглүүлэн тусгай тэмдэглэлийг үйлдүүлэх ба зарим чухал болох булшийг туршиж малтах" зэрэг олон чухал ажлуудыг эрчимтэй хийж эхэлсний дотор Налайхад буй VII зууны дурсгалыг тойруулан хашаа татан⁵ хамгаалах ажлуудыг хийсээр иржээ. Түүх соёлын дурсгалыг авран хамгаалах ажлын зэрэгцээ бас нэг чухал зорилт болон тавигдсан зүйл бол "БНМАУ-ын нутаг дотор буй хуучны дурсгалт зүйлүүдийн бүртгэл товчийг зохиох"⁶ явдал байсан бөгөөд Х.Пэрлээ "Монгол Ард Улсын археологийн картын сан" нэртэйгээр хийж гүйцэтгэжээ. Тэрээр Түүхийн кабинетэд хориод жилийн турш хуримталсан мэдээ зүйлс ба орос эрдэмтэн нарын XYIII зууны үеэс эхлэн 140-50

² БНМАУ-ын түүх. Тэргүүн боть (нэн эртнээс XYII зуун) УБ., 1966, 13-р тал

³ Мөн тэнд. 14-р тал

⁴ Б.Ширэндэв. БНМАУ-ын ШУА-ийн товч түүх УБ., 1980 т.15-16

⁵ 1941 оны ажлын тайлан //ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №8

⁶ 1937 оны Түүхийн тасгийн ажлын төлөвлөгөө //ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №6

жилд бүртгэн тэмдэглэсэн археологийн дурсгалуудын мэдээ зангийг үндэс болгон⁷ 1941 оны эцсээр зохиож эхэлсэн бөгөөд түүнээс хойш хэд дахин шинэ материалаар баяжуулан, нэмэн засварлажээ. Х.Пэрлээ дэлхийн дайны гал ид дүрэлзэж асан 1942 онд Төв аймгийн Авдар баян сумын нутаг Хүйтний голд бие дааж хэдэн булш малтсан нь Монгол улсын нутагт монгол хүн анх удаа эх нутгийнхаа хэвлийд хадгалагдсаар ирсэн түүх, соёлын дурсгалыг шинжлэх ухааны үүднээс малтан шинжилсэн хэрэг байлаа⁸.

БНМАУ-ын түүхийн (нэгэн боть) анхны ботийг зохиогчид энэ үед дотоодод хийсэн ажлыг үнэлэн бичихдээ “БНМАУ-ын ШУ-ны хүрээлэнгээс сүүлийн жилүүдэд дурсгалуудыг шинээр илрүүлэн бүртгэх, археологийн хэрэглэгдэхүүнийг арвижуулах ажлыг хийсээр байгаагийн үрээр ... Үндэсний музейд хуримтлагдаад байгаа археологийн чуулбарыг тэмдэглэхгүй байхын аргагүй” хэмээгээд Х.Пэрлээ БНМАУ-ын эрт үеийн дэлгэрэнгүй картыг бүрдүүлсэн⁹-г онцлон сайшаажээ. Энэ үеийн археологийн шинжилгээний ажлыг манай судлаачид түүх-археологийн ба этнографи-археологийн холимог шинж чанартай¹⁰ байсныг онцолсон байна. Ингэж манай үндэсний мэргэжлийн байгууллагаас эх орныхоо түүх соёлын баялаг дурсгалыг нээн илрүүлэх, авран хамгаалах, бүртгэн баримтжуулах болон малтан судлах ажлуудыг Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар болон дангаараа хийх болсон нь манай уламжлалт түүх бичлэгт гарч байгаагүй цоо шинэ үзэгдэл байсан юм.

1921-1940 онд Шинжлэх ухааны хүрээлэнгээс 44 ном, 3 толь бичиг нийтлүүлсний дотроос дорвитойг нь дурдвал: “Автомитын үеийн гадаад Монгол” (Г.Навааннамжил), Манжийн эзэрхийллийн үеийг хүртлэх тус улсын түүхийг бүхэлдээ хамарсан “Монголын товч түүх”(А.Амар 1934), Автомитын үеийн тус орны түүхийг харуулсан “Монголын товч түүх”(Л.Дэндэв 1934) зэрэг болно. Нийгэм эдийн засгийн дүн шинжилгээгүй ишлэл зүүлтгүй бичсэн эдгээр бүтээлд түүхэн үйл явц дахь ард түмний ролийг бүрэн товойлгож чадаагүй¹¹ хэмээн марксист түүх бичлэгийн үзэл суртлын ноёрхлын үед ангич байр сууринаас шүүмжлэлтэй хандаж байсан ч уг бүтээлүүд нь түүхийн өнгөрсөн үйл явдлуудыг цэгцлэн эмхтгэх гэсэн анхны оролдлого байснаараа цаг үедээ хэрэгтэй болохыг нь үгүйсгэж байгаагүй юм.

• Монголын эртний түүх бичлэг уламжлалт бичлэгийн хэв маягаас марксист онол-арга зүйн давамгайлалд бүрэн автах болсон үе буюу 1949 – 1969 оны хоорондын 20 жилд туурвисан бүтээл тооцогдож болох юм. Он цагийн хязгаарыг нарийвчлан өгүүлэхийн учир нь Монгол, Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран туурвисан анхны марксист бүтээл “БНМАУ-ын түүх” нэгэн ботийг зохиох ажлын хүрээнд 1948-1949 онуудад ажилласан С.В.Киселевийн экспедицийг хугацааны эхэн болгож болох үндэслэл байгаа юм. Нөгөөтэйгүүр 1949 онд МАХН-ын ТХ-ны Улс төрийн Товчоо “Ардын унших бичгийн тухай”, “БНМАУ-ын түүх ба утга зохиолыг сургуулиудад зааж байгаа байдлын тухай” тогтоол гаргасан нь түүхийн шинжлэх ухаанд марксист онол-арга зүйн зарчмууд батжин бэхжихэд томоохон түлхэц үзүүлсэн байна. Чухам энэ үеэс түүхийн ном, бүтээлүүдэд үзэл суртлын хатуу хяналт тавьж, түүхийн бодит баримтыг ангич, намч зарчмын үүднээс алагчлан сонгож, нэг талыг барьсан өрөөсгөл, ташимгай дүгнэлт хийх болжээ.

⁷ БНМАУ-ын түүх. Тэргүүн боть (нэн эртнээс ХҮИ зуун) УБ., 1966, 14-р тал,

⁸ А.Очир, Д.Цэвээндорж. Академич Х.Пэрлээ (1911-1982) // Х.Пэрлээ ЭШ-ны өгүүллүүд эмхтгэлд бичсэн удирдтгал

⁹ История МНР М., 1954, стр-15

¹⁰ БНМАУ-ын түүх. Тэргүүн боть (нэн эртнээс ХҮИ зуун) УБ., 1966, 14-р тал, Монгол улсын түүх 5 боть, I боть УБ., 2003 т-

¹¹ Б.Ширэндэв. БНМАУ-ын ШУА-ийн товч түүх УБ., 1980 т.14

Өнгөрсөндөө бодитой хандах эрмэлзлэл бүхий түүхчид, түүх сонирхогчдыг үндсэрхэг үзэлтэн хэмээн хавчин шахаж нухчин дарах болсон байна. Ингэж түүхийн судалгаанд марксист түүх бичлэг эргэлтгүй ноёрхох эхлэл¹² тавигдсан нь эртний түүхийн судалгаанд бас нэгэн шинэ хуудас болжээ. Харин монголын эртний судлалыг цоо шинэ түвшинд хүргэсэн МЗТСХЭ-ийн албан ёсоор зохион байгуулагдсан 1969 оныг мөн үеийн дуусгавар болгож болох юм.

1948-1949 оны Монгол-Зөвлөлтийн түүх-этнографийн хамтарсан экспедицийн судалгааны үр дүнд Монгол нутгийн эрт дундад үеийн олон арван шинэ дурсгалуудыг нээн илрүүлснээр тогтохгүй үндэсний археологичдын арга зүйн өсөлтөнд шууд нөлөөлөн хэрэг дээрээ монголын орчин үеийн археологийн шинжлэх ухааны үндсийг тавьсан хэрэг болжээ. Монголд археологийн шинжилгээний ажил нь нэлээд эрт эхэлсэн авч шинжээчдийн их төлөв нь жинхэнэ археологич бус байсан учраас Монголын түүхийн бодит материалаар нотлон баталсан түүхийн бүтээлүүд үгүй байгаа юм. Гагцхүү 1948 оноос эхлэн өөрөөр хэлбэл, эрдэмтэн Киселеваас явуулсан системчилсэн ухлагуудаас Монголд археологийн шинжилгээний ажил нь одоогийн түүхийн шинжлэхүй ухааны шаардлагад тохирон эхэлсэн гэж үзэх ёстой¹³ хэмээн ахмад археологич Ц.Доржсүрэн үзсэн нь манай орчин цагийн археологийн шинжлэх ухааны суурь тавигдсан болохыг өгүүлжээ. Х.Пэрлээ энэхүү эрдэм шинжилгээний ангид Монголын талын удирдагчаар, Зөвлөлтөд мэргэжил эзэмшиж байсан Н.Сэр-Оджав, Ц.Доржсүрэн, Д.Наваан нарын манай ахмад үеийн төлөөлөл биечлэн оролцсон нь монголын археологийн сургуулийн цаашдын хөгжилд томоохон түлхэц болжээ. Энэ тухай Ц.Доржсүрэн "... эрдэмтэн Киселевийг буцсанаас хойш Пэрэнлэйгээс Киселевийг дагаж ажиллан сурсан арга техникийг хэрэглэн шинжилгээний ажлыг гурван жил шахам хийж, ирээдүйд чухал зүйл болох хайгуулуудыг явуулсан ба урьд мэдэгдээгүй хот балгасуудыг ч олсон байна"¹⁴ хэмээн үнэлэн бичиж байснаас харагдаж байна.

1948-1949 онуудад явагдсан Монгол-Зөвлөлтийн түүх-угсаатны зүйн хамтарсан экспедицийн үйл ажиллагаанд монголын судлаачид оролцсон явдал нь манайд орчин цагийн археологийн шинжлэх ухааны салбар үүссэн гэж үзэх үндэслэлтэй тухай бид дурдлаа. Тиймээс ч энэ 2008 онд манай археологийн шинжлэх ухааны салбар үүссэний 60 жилийн ойг тэмдэглэх нь зүйтэй мэт санагдана. Х.Пэрлээгийн араас 1950-иад оноос уул экспедицид оролцон ажиллаж байсан Н.Сэр-Оджав, Ц.Доржсүрэн нар мэргэжлийн сургууль дүүргэн ирж бие даасан хайгуул, судалгаа хийх болсноор манай археологийн шинжлэх ухааны үүслийн тулгын чулууг тавилцсан анхдагчид болжээ.

Дайны дараах жилүүдэд Зөвлөлтөд болон Үндэсний их сургуулиар марксист онол-арга зүй эзэмшсэн судлаачид олноор төрөн гарч, өргөн хүрээнд судалгаа хийх болсноор түүхийн шинжлэх ухааны хөгжил эрчимжин, судалгааны цар хэмжээ, агуулга, сэдэв өргөжсөнөөр зөвхөн археологи төдийгүй угсаатан судлал, түүх бичлэг зэрэг салбар ухаан буй болжээ. Энэ бүхэн нь Н.Сэр-Оджавын онож хэлснээр "эх түүхээ нэн эртнээс эхлэн үе шатлан судалж археологи, этнографийн болон бичмэл хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монголын хүй нэгдлийн байгуулал, Монгол оронд удаа дараалан тогтож байсан эртний улс гүрний түүхийг марксист-ленинист арга судлалын үүднээс анх удаа боловсруулахад"¹⁵ хүргэжээ. 1954 онд орос, монгол хэлээр хэвлэгдсэн БНМАУ-ын түүх (нэгэн боть) зохиол нь тухайн үед

¹² Ж.Болдбаатар, Д.Батбаяр. Дурьдсан зохиол

¹³ Шинжлэх ухааны хүрээлэнгийн 1953 онд гүйцэтгэсэн ажлын тайлан // ШУА-н Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №6

¹⁴ Мөн тэнд

¹⁵ Н.Сэр-Оджав. Эх орны түүхийг судалсан 50 жил // ШУА-ийн мэдээ. № 4, УБ., 1971

монголд хийгдээд байсан археологийн судалгааны үр дүнг чулуун зэвсгийн үеэс эхлэн дундад үеийн түүхийг улируулан судлах гол сурвалж болгон марксист түүх бичлэгт нэвтрүүлсэн онол-арга зүйн чиглүүлэгч бүтээл болсон байна.

Ийнхүү манай оронд 1950-иад оны эхэн үеэс эх үндэс нь тавигдсан археологийн салбар шинжлэх ухаан марксист арга зүйн туган дор түүхийн тодорхой үеүүдийг баримжаа болгон хөгжих хандлагатай болсон бөгөөд анхны хүй нэгдлийн археологи, эртний улсууд (Хүннү, Түрэг, Хятан)-ын археологийн шинжилгээг манай судлаачид гол төлөв бие даан, заримдаа Зөвлөлт болон бусад социалист орны эрдэмтэдтэй хүч хавсран явуулж байлаа. Монголын үндэсний боловсон хүчин, ихээхэн өсч өндийн онол-арга зүйн зохих бэлтгэлтэй болсныг тэдний нийтлүүлж эхэлсэн бүтээлүүд гэрчилдэг юм. Х.Пэрлээ, 1951 оны 4-р улиралд "Монгол тэрэгний цөн"¹⁶ өгүүлэл бичиж, 1952 онд "Монголын эртний овог, аймаг, ястны түүхийг судлахад археологийн ач холбогдол", "1951-1953 онд явуулсан археологийн шинжилгээний тухай товч мэдээ"-г 1954 онд тус тус нийтлүүлсэн бол Монголын чулуун зэвсгийн талаар Н.Сэр-Оджав, Ц.Доржсүрэн нар тусгайлан судлаж, анхны өгүүлэлүүдээ¹⁷ хэвлүүлсэн байна.

Монгол орныг археологийн талаар судлан шинжлэх ажил эрчимжин, эх хэрэглэгдэхүүн хуримтлагдахын хирээр тэдгээрийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан байдлын талаар нэгтгэн дүгнэсэн түүх бичлэгийн бүтээл хэвлэгдэх шаардлага аяндаа урган гарах болсон байна. Үүнийг анх С.В.Киселев 1922-1946 оны хооронд манай улсад явуулсан археологийн ажлын шинжилгээний дүнг нэгтгэн "Монгол орон эрт цагт" нэртэйгээр өгүүлэл болгон хэвлүүлж¹⁸ байсан бөгөөд энэ нь "БНМАУ-ын түүх" анхдугаар ботид үндсэн сурвалжийн нэг болж орсон байна. Уг зохиолын тэргүүн хэсэгт хүн Монгол нутагт амьдрах болсон цаад хугацааг дээд палеолитоор тогтоосноос эхлээд Кидан гүрнийг хамруулан Монголын эртний түүхийн судалгааны тоймыг¹⁹ бичсэн нь дараа үе үеийн судлаачид тухайн цагийн шинжлэх ухааны түвшинд тохируулан баяжуулан бичих үндсийг тавьжээ.

Археологийн судалгааны тойм нь судлаачдын дэвшүүлсэн онолын үзэл баримтлал, гаргалгаа, хүрсэн үр дүнгийн талаар нарийвчлан өгүүлээгүй хэдий ч тухайн цаг бүрийн археологийн шинжлэх ухааны хүрсэн амжилт бүрийг хураангуйлан илтгэсэн түүх бичлэг учраас ач холбогдол өндөртэй юм. Тухайлбал, өгүүлэн буй үед археологийн судалгааны тоймыг анх бичсэн хүн бол Х.Пэрлээ авгай билээ. Тэрээр "Монголын археологи 30 жил"²⁰ өгүүлэл бичин түүнийгээ баяжуулан хожим тусгай товхиц²¹ болгон хэвлүүлсэн бололтой. Зохиогч археологийн судалгааг түүхэн цаг үеэр нь үечлэн овог-аймгийн байгууллын үе, аймгийн холбоо, эртний улсын үе, 12-17 дугаар зууны үеийн түүхийн дурсгал гэсэн гурван хэсэгт хуваан үзсэн нь шинжлэх ухааны үндэслэлтэй эдүгээгийн археологийн үечлэлийн үндэс болжээ. Нэгэн боть зохиолын үзэл баримтлалаар Монголын чулуун зэвсгийг палеолит, неолитын үе шат дамжсан болохыг дурдан өгүүлж, Монгол орон хүрэл зэвсгийн (МЭӨ 14-10-р зууны) үед Сибирь, Хойд Хятад

¹⁶ ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив, №6-р хавтас

¹⁷ Н.Сэр-Оджав "Монгол орны неолитын үеийн тухай" 1956, "Дорноговиос эртний хүний ул мөр олдлоо" 1957, Ц.Доржсүрэн "БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсгийн судлалын байдал" УБ., 1957, "Улсын төв музейд байгаа чулуун зэвсгийн зүйлс" УБ., 1959

¹⁸ С.В.Киселев. Монголия в древности "Известия АН СССР" Серия истории и философии. М., 1947, т. IY, №4

¹⁹ История МНР. М., 1954 стр 13-15

²⁰ ШУХ-ийн Түүхийн кабинетын 1951 оны 4-р улирлын ажлын төлөвлөгөө //ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №6

²¹ Х.Пэрлээ. Монгол орны археологийн шинжилгээний товч тойм. УБ., 1957

хоёрын соёлын харилцан нэвтрэлцэхэд гүүр дамжуур нь болж байсан бололтой хэмээн дүгнэн бичжээ. Монгол нутагт оршин асан эртний улсууд болон 12-17-р зууны үеийн Монгол нутаг дахь түүхийн дурсгалуудыг судалсан талаар өгүүлсэн нь олон нийтэд археологийн шинжлэх ухааны ололтыг сурталчилсан танин мэдэхүйн шинжтэй бүтээл ажээ.

Н.Сэр-Оджав Шинжлэх ухаан сэтгүүлийн 1956 оны №3-т нийтлүүлсэн “Нийгэмлэгийн шинжлэх ухааны талаар 35 жилд хийсэн ажил” өгүүлэлдээ Монгол орныг археологийн талаар шинжлэн судлах ажил 1922 оноос эхлэлтэй гээд 1924-1926 онуудад Ноён ууланд хийсэн малтлагагаар дэлхийн шинжлэх ухаанд нэр гарсан маш ховор зүйлүүдийг олсон тухай онцлон тэмдэглэжээ. Тэрээр 1963 онд “40 жилд БНМАУ-д хийсэн эртний судлалын шинжилгээ” өгүүлэл хэвлүүлсэн нь манай түүхчдийн археологийн судалгааны тоймыг хураангуйлсан 2 дахь бүтээл болсон билээ. Монголын түүхийн бүх үеийн археологийн судалгааны төлвийг дүгнэн өгүүлэхээс гадна археологийн тодорхой нэг үеийн судалгааны тоймыг товчоолон хураангуйлсан анхны бүтээлүүд болох Н.Сэр-Оджавын “Монгол орны неолитын үеийн тухай”²², Ц.Доржсүрэн “БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсэг судлалын байдал”²³ товхиц хэвлэгдэн гарчээ. Х.Пэрлээ 1952 онд “Чулуун зэвсэг” 0.5х,х өгүүлэл бичсэн нь²⁴ бид хараахан олж чадаагүй байна.

1950-д оноос эхлэн эртний судлалын шинжилгээний ажлыг их төлөв манай улсын өөрийн эртний судлалч мэргэжилтэн нарын хүчээр хийх болсон бөгөөд шинжилгээний ажлын голыг БНМАУ-ын 3 боть зохиоход чиглүүлж байв. Үүнд: тус улсын нутагт хүн анх нутаглах болсон ба эртний хүмүүсийн овгийн байгууллын үүсэл, түүний уналт, ангит нийгэмлэгийн үүсэл, анхны улсуудын бий болсон тухай асуудлыг тодорхойлон судлахад гол анхаарал тавин²⁵ иржээ.

Харин 1950-д оны сүүл үеэс Монгол улсын түүхийг шинэчлэн бичих бэлтгэл ажлын хүрээнд Зөвлөлтийн тусламжтайгаар археологийн хээрийн шинжилгээний ангийг явуулах болсон байна. Ийнхүү археологийн шинжилгээг өргөн хүрээтэй тогтмол явуулах болсноор монголын эртний түүхэнд холбогдох бараг бүх үеийн дурсгалуудаас нээн илрүүлж, түүний үр дүнд манай судлаачдын судалгааны нэгэн сэдэвт зохиолууд цувран гарах болжээ. Х.Пэрлээ “Хятан нар тэдний монголчуудтай холбогдох нь” УБ., 1959, “Монгол ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоон” УБ., 1961, Ц.Доржсүрэн “Умард хүннү” УБ., 1961 зэрэг зохиолууд нь хэвлэгдэн гарсан нь Монгол эрдэмтдийн эртний судлалаар туурвисан анхдагч нэг сэдэвт бүтээлүүд байлаа. 1960 оноос манай мэргэжлийн анхны тогтмол сэтгүүл “Археологийн судлал”-ын эхний дугаар хэвлэгдэн гарсан нь эртний судлалын шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замыг хурдасгажээ.

1966 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх” зохиолын тэргүүн ботид Х.Пэрлээ “Монголын ард түмний түүхийн уг сурвалж зүйл, үндсэн зохиолын хураангуй тойм”-г бичжээ. XIX зууны эцсээс тухайн цаг үеийг хүртэл Монгол оронд явагдсан археологийн бүх судалгааг чиглэл бүрээр нь ангилан үечилж дурдсан байна. Энэхүү судалгааны тоймыг дараа үеийн судлаачид баяжуулан нэмэн бичих замаар өнөө үетэй золгуулжээ. “БНМАУ-ын түүх” зохиолын тэргүүн боть нь үндсэндээ Монголын түүхийн эртний үеийг хамарсан бөгөөд манай тухайн үеийн шилдэг эрдэмтэд бичсэн ч “...түүхийн I ботийн загварыг ноднин жил ЗХУ-ын ШУА-д илгээж, Зөвлөлтийн эрдэмтэн нарын санал зөвлөгөөнийг авсан бөгөөд энэ онд

²² Н.Сэр-Оджав. Монгол орны неолитын үеийн тухай // ШУА-ийн ЭШ бүтээл. 1956, №1

²³ Ц.Доржсүрэн. БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсэг судлалын байдал УБ., 1957

²⁴ ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив, №6-р хавтас

²⁵ Н.Сэр-Оджав. 40 жилд БНМАУ-д хийсэн эртний судлалын шинжилгээ (эртний судлал-угсаатны зүйн бүтээл) // SA. Т.II, F.I УБ., 1963

тэдгээр санал зөвлөгөөний дагуу эцсийн засвар хийж хэвлэлд шилжүүлсэн”²⁶ нь монголын түүх бичлэг түүний дотор эртний судлалын салбар бүхэлдээ Зөвлөлтийн мэргэжлийн байгууллагын хатуу хяналтын дор нэгэнт орсныг харуулах баримт юм.

• Монголын түүх бичлэг дэхь марксист-ленинист үзэл суртлын засаглалын хэтийдэл ба мөхөсдлын доорхи буюу 1969-1989 оны хоорондох эртний судалгаа. 1969 оны 5-р сарын 28-нд Москва хотноо хоёр талын төлөөлөгчид гарын үсэг зурснаар үйл ажиллагаа нь эхэлсэн²⁷ МЗТСХЭ-ийн монгол нутагт явуулсан 20 жилийн судалгааны туршид хуримтлагдсан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан бичсэн бүтээлүүдийг энд тооцож болох юм.

БНМАУ-ын түүх 3 боть зохиол хэвлэгдэн гарснаас хойш Монгол-Зөвлөлтийн археологи, этнографийн ангийн зохион байгуулалт цаашид улам бэхжиж судалгааны цар хүрээ нь тэлж ирсэн учир 1969 онд МЗТСХЭ болгон ийхүү өөрчилжээ. Энэ ангийн 20 жилийн судалгааны үр дүнд Монголын төдийгүй Төв Азийн түүхийн олон ээдрээтэй асуудлуудад хариулт өгөхүйц чухал чухал нээлтүүд хийгдэж, түүхийн судалгааны эх сурвалжийн сан хөмрөгийг шинэ соргог эх хэрэглэгдэхүүнээр нэн баяжуулжээ. Энэ нь манай эртний түүх бичлэгийг судалгааны шинэ түвшинд хүргэсэн нь судлаачдын бүтээлүүдээс тодорхой харагддаг юм. Түүхийн аль нэг үе, чиглэлээр дагнасан судалгааг эрчимтэй хийж, хуримтлагдсан баялаг эх хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах хэлбэр нь чанаржиж “... А.Окладниковын удирдлагын дор Н.Сэр-Оджав докторын зэрэг, Д.Дорж дэд эрдэмтний зэрэг хамгаалсны дээр экспедицийн материалаар Д.Наваан, Д.Цэвээндорж нар дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.”²⁸ Хамтарсан экспедицид оролцогч Монгол, Зөвлөлтийн эрдэмтдийн туурвисан суурь судалгааны томоохон бүтээлүүд энэ үед хэвлэгдэн гарсан нь манай археологийн судалгааны оргил үе байлаа.

Д.Дорж “Неолит Восточной Монголии”, Д.Дорж, Э.А.Новгородова “Петроглифы Монголии”, Д.Дорж, Д.Цэвээндорж “Монголын палеолит”, Д.Наваан “Дорнод Монголын хүрлийн үе”, Н.Сэр-Оджав “Эртний түрэгүүд (VII-VIII)”, Д.Цэвээндорж “Чандманский могильник-памятник раннего железного века Монголии” гэх мэт монгол эрдэмтдийн туурвисан эртний судлалын томоохон бүтээлүүд хэвлэгдэн гарсны зэрэгцээ судалгааны олон зуун өгүүлэлүүд энэ үед бичигджээ. Монгол нутагт 20 жил тасралтгүй ажилласан МЗТСХЭ-ийн судалгааны үр дүнд хуримтлагдсан баялаг эх хэрэглэгдэхүүн нь эдгээр зохиолууд бичигдэхэд голлох сурвалж нь болсон байна.

Өгүүлэн буй үед манай эрдэмтдийн эртний түүхийн сэдвээр туурвисан бараг бүх бүтээлүүдэд хамтарсан экспедицийн ололт амжилт тусгагдсны дотор энэ үеийн түүх бичлэгийн голлох бүтээл “БНМАУ-ын түүх” нэгэн боть зохиолыг нэмэн засварлаж 3 дахь удаа хэвлэхэд үндсэн хэрэглэгдэхүүн болжээ. Өнөө үед ч хамтарсан экспедицийн хуримтлуулсан эх хэрэглэгдэхүүнээр эртний түүхийн дорвиллог бүтээлүүд хэвлэгдсээр байгаагийн нэг нь манай түүхчдийн бичсэн “Монгол улсын түүх” 5 боть зохиолын тэргүүн дэвтэр юм. Энд хамтарсан экспедицийн 20 жилийн ажлын үр дүн болон тэдний нээн илрүүлсэн дурсгалыг дараа үед үргэлжлүүлэн хийсэн судалгаан дээр бичигдсэн түүхийг өгүүлсэн байна.

Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн хамтарсан судалгаа нь шууд оюуны үйлдвэрлэлд их, дээд, дунд боловсролын сургуулийн монголын түүхийн хичээлийн сургалтанд манай өсвөр, залуу үеийнхний эх оронч хүмүүжил олгох түүхийн

²⁶ БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн 1965 оны Эрдэм шинжилгээний ажлын тайлан // ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №72

²⁷ МЗТСХЭ-ийн ажлын зорилго, танилцуулга, тайлан 1984 // ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №

²⁸ МЗТСХЭ-ийн ажлын зорилго, танилцуулга, тайлан 1984 // ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн архив

мэдлэг буюу бүтээгдэхүүн болсоор байна. Энэ үеийн эртний судлалын бүтээлүүд нь нэн эрт цагаас монгол нутагт хүн тасралтгүй суурьшсаар ирснийг нотлох, монголчуудын угсаа-түүхийн асуудлыг олон талаар хөндсөн эрдэм шинжилгээний шинэ дүгнэлтүүдээр арвин байв. Дээрх хугацаанд хэвлэгдэн гарсан эртний түүхийн судалгааны зохиолууд нь бүхэлдээ БНМАУ-ын түүх 3 боть зохиолын үзэл баримтлалын хүрээнд хаад, язгууртны нийгэмд гүйцэтгэх тэргүүлэх үүрэг, ролийг дарлагч этгээдийн ажиллагаа болгон харуулахыг оролдсон ангийн байр сууринаас бичигдсээр ирсэн нь энэ үеийн түүх бичлэгийн ялгарах онцлог юм.

Гэвч энэ 20 жилийн археологийн судалгаа нь монголын эртний түүхийн цагаан толбо болсоор ирсэн олон асуудлуудад хариулт өгсөөр ирсэн юм. Тухайлбал, Монголын чулуун зэвсгийн судалгаа нь Монгол нутагт хүн нутаглах болсон цаад хугацааг нэн эрт буюу ашелийн үе (300 000 жилийн өмнө)-р тогтоон орон нутгийн бие даасан соёл байсныг илрүүлжээ. Хүрэл, төмрийн түрүү үе, эртний улсуудын түүхийн тухай мэдлэг археологийн хэрэглэгдэхүүнээр ихээхэн баяжигдсан ч Н.Сэр-Оджав "...бид палеолит, неолитын талаар юм хэлж чадах болжээ. Хүрлийн талаар энэ хоёрт хүрэхгүй ч гэсэн ерөнхий юм хэлж чадахаар байна. Хүрлээс хойшхи хүннү хүртэл, хүннүгээс хойшхи үеийг бид муу мэдэж байна"²⁹ хэмээн өгүүлсэн нь товчхондоо археологийн хөгжлийн тухайн цаг үеийн түвшинг илтгэсэн хэрэг байлаа.

• 1990-ээд оны түүхэн их өөрчлөлтөөр Монголчуудын оюуны амьдралын хүрээнд гарсан үндсэн эргэлт нь түүх бичлэгт гүнзгий тусгалаа олж академич Ж.Болдбаатарын тодорхойлсноор түүхийн шинжлэх ухааныг түүхэн хүн судлалын чиглэлтэй болгон түүхэн үйл явцын субъектив, сэтгэл судлалын талыг голлон анхаардаг өрнөдийн орнуудын түүхэн сургуулийн арга зүйн шинэ хандлага нэвтрэн эхэлж байгаа үе³⁰ юм. Сүүлийн 50-д жил түүх бичлэгт ноёрхсон марксист уламжлалыг халж, түүх бичлэгийн онол-арга зүйн шинэ орон зайд өрнөдийн орчин үеийн сургуулиуд нэвтэрч эхэлснээр манай шинэ үеийн эртний түүх бичлэгийн бас нэгэн онцлог шат эхэлсэн билээ. 90-д оноос хойш Монголын археологийн шинжлэх ухаанд гарсан цоо шинэ үзэгдэл бол өрнөдийн тэргүүлэх орнуудтай хамтарсан экспедицийг удаа дараалан зохион байгуулж хүрсэн үр дүнгийн талаар монгол болон тухайн орнуудын хэлээр нийтлэх болжээ. Ялангуяа чулуун зэвсгийн үеийн судалгаа ихээхэн амжилт олж Монгол нутагт наанадаж 730-д мянган жилийн өмнөөс хүн нутаглах болсныг тогтоожээ.

Хүннү судлалд шийдэгдээгүй олон асуудлуудад археологийн эх хэрэглэгдэхүүнээр хариулт өгч байгаа нь томоохон амжилт юм. Хүннүгийн угсаа гарвалын талаар монголчуудтай холбогдох нотолгоо, соёлын эх үүсвэр, тархалтын хил хязгаарын судалгааг шинэ түвшинд хүргэснээр тогтохгүй малтлагын арга зүйг ч боловсронгуй болгожээ. Тахилтын хотгор, Тамирын Улаан хошуу, Гол мод, Гол мод II, Ноён уул, Дуурилаг нарс, Өгөөмөр уулнаа байх хүннүгийн оршуулгын газруудад голлон малтлага хийжээ. Эдгээрээс Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын хөндийн Бурхан толгойд орших хүннүгийн оршуулгын газрыг бүхэлд нь малтан шинжилсэн нь ихээхэн онцлогтой юм.

Энэхүү судалгаагаар хүннүчүүдийн ураг-төрлийн хамаасал, хүн ам зүйн асуудал гэх зэрэг нийгмийн шинжтэй асуудлууд болон оршуулгын дотоод, гадаад зохион байгуулалтын талаар шинэ дүгнэлтэнд хүрсэн нь монголын хүннү судлалын томхон амжилт болжээ. З.Батсайхан, Ц.Төрбат, Ч.Амартүвшин нарын эрдмийн зэрэг горилж бичсэн бүтээлүүд нь энд хийгдсэн судалгааны үрээр

²⁹ Түүхийн хүрээлэнгийн ЭЗ-н хурлын протокол 1971.12.11 // ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн архив. Хавтас №92

³⁰ Монгол улсын түүх. Ү боть, УБ., 2003. 31-р тал

хуримтлагдсан эх хэрэглэгдэхүүн дээр голчлон бичигдсэн нь бүлэг булшны судалгаа эрдэм шинжилгээний ихээхэн ач холбогдолтой болохыг харуулсан хэрэг юм. Хүннү судлалд ийнхүү амжилт олж байгаа боловч монгол угсааны төр улсуудын үе, монгол аймгуудын археологийн судалгаанд шийдвэрлэгдэх олон асуудлууд хариу хүлээсээр байна.

1990-ээд оноос хойш археологийн судалгааны томоохон төсөлт ажлууд хэрэгжсэн бөгөөд одоо ч зарим нь үргэлжилсээр байна. Тухайлбал, Японтой хамтарсан "Гурван гол", Солонгосын талтай "Дорнод Монгол", Америк, Оростой хамтарсан "Монголын чулуун зэвсгийн үе" болон Францтай хамтран Эгийн гол, Гол модны дурсгалуудыг судлах төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Эдгээрээс гадна Америктай хамтарсан "Өмнөд Монголын археологийн хайгуул", Германтай хамтарсан "Хархорин" зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна. Ийнхүү Монгол орныг археологийн талаар судлах, хамтран ажиллах сонирхол эрс өссөн нь энэ салбарын хөгжлийг ихэд хурдасгахад хүргэжээ. 2003 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс Археологийн судалгааны төв нь бие даан салснаар мэргэжлийн хүрээлэн болон өргөжиж эдүгээ монголын археологийн бүх үеийн судалгааг хийж байна. 1996 онд МУИС-ийн НУФ-ын бүрэлдэхүүнд Археологи-Антропологийн тэнхим байгуулагдсан цагаас хойш мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхийн зэрэгцээ дотоодын эрдэм шинжилгээний экспедицүүдийг жил дараалан томилон явуулснаар багагүй амжилтанд хүрчээ.

Монголын археологийн судалгаа нь шинэ үеийн түүх бичлэгт марксист-ленинист онол арга зүйн эрчимжилтийн түвшин болон судалгааны цар хүрээнээс шалтгаалан дараах дөрвөн үе шатыг туулан иржээ. Үүнд:

- 1921-1940-д оны сүүл үе хүртэл хугацаанд монголчууд эртний дурсгалуудыг авран хамгаалах болон эрэн сурвалжлах ажлыг завсарлагтай боловч хийсээр ирсэн нь манай археологийн шинжлэх ухаан үүсэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлжээ.

- 1949-1969 оны үед Монголын археологийн шинжлэх ухаан үүсч хөгжин, монголчуудын археологийн суурь судалгааны томоохон бүтээлүүд хэвлэгдэн гарчээ. С.В.Киселевын удирдсан Монгол-Зөвлөлтийн түүх-угсаатан судлалын экспедицид манай археологичид оролцсон болон үндэсний сэхээтнүүд чулуун зэвсгийн судалгааг хийж эхэлсэн 1949 оноос Монголын археологийн шинжлэх ухаан үүсэн бий болсон гэж үзэж байна

- 1969-1989 оны хоорондох 20 жил МЗТСХЭ-ийн судалгааны үе бөгөөд монголын археологийн хөгжил шинэ түвшинд хүрсэн байна. Монголын археологийн суурь судалгааны голлох бүтээлүүд энэ үед хэвлэгдэн гарснаар эртний түүхийн олон ээдрээтэй асуудлуудад хариулт өгсөн байна

- 1990-ээд оноос хойш өнөө үеийг хүртэл археологийн судалгаанд барууны тэргүүлэх орнуудын арга туршлага нэвтэрч, судалгааны байгууллагууд ихээхэн бэхжиж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэн гаргах болжээ.

Abstract: The archaeology of Mongolia has four periods in its history which differs from each other by research intensiveness of methods and theories of Marxist-Leninist paradigm.

1. 1921-1940. The foundation period. Archaeological and ancient monuments were searched and redeemed from defects with some interruptions.

2. 1949-1969. The beginning period. The Mongolia's archaeology had been developed and several great works were published on Mongolian archaeology prime surveys. The our first archaeologists were born from the joint expedition of People's Republic of Mongolia and Soviet Union led by S. V. Kiselev and started surveys on

paleolithic sites. The foundation year of Mongolia's archaeology is 1949 as the author's opinion.

3.1969-1989. The next period. The joint expedition of PR Mongolia and Soviet union had reached new level of archaeological survey. The basic theory books were published and ancient history problems were solved by the theory books deliberately.

4.Since 1990. Unknown Eastern archaeological theories and methods were introduced and were used by Mongolian archaeologists. The main centres and institutes of archaeological expeditions and surveys have been developed.